

ОЛОН НИЙТИЙН ГАЗРЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ХАНДЛАГА

Г.Болор-Эрдэнэ

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Товчлол: Энэхүү өгүүлэлээр олон нийтийн газрын аюулгүй байдлын байдлыг хангах нь төрийн болон цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүнг хэмжих хамгийн чухал үзүүлэлт гэж зүй ёсоор үздэг. Гэмт хэргийн үзүүлэлтийг хууль сахиулах байгууллагын дотоод үнэлгээнд голчлон ашигладаг дэлхийн ихэнх улс орнуудад хамгийн оновчтой арга гэж хүлээн зөвшөөрдөг бөгөөд иргэд олон нийтийн зүгээс олон нийтийн газрын аюулгүй байдлын талаар өгч байгаа үнэлгээ нь аюулгүй байдлын системийн үр нөлөөг тодорхойлоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг..

Abstract: In this article, The state of security in public places has rightfully come to be considered as the most important indicator of the effectiveness of the activities of government authorities, as well as the police. This approach is recognized as optimal in most countries of the world, where crime indicators are mostly used for internal assessment of the work of law enforcement agencies, and the corresponding assessments of citizens are recognized as decisive in determining the effectiveness of the entire security system.

Түлхүүр үгс: Олон нийтийн газар, олон аюул заналхийлэх, халдлагаас урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогч.

Key words. Public places, threats in public places, prevention of assaults, victim of crime in a public place.

Оршил. Төрийн бүх шатны байгууллага, тэр дундаа цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны гол зорилго нь улс орон, хүн амын аюулгүй байдлыг гадаад, дотоод аюулаас хамгаалахад оршино. Энэ нь улс төр, нийгмийн салбар, хууль тогтоох, хууль сахиулах үйл ажиллагаанд зөв чиг хандлагыг тогтоох, сонгох боломжийг бий болгож байдаг. Үүнтэй холбогдуулан олон нийтийн газрын аюулгүй байдлын талаарх иргэдийн

санаа бодол, хандлагыг тодорхойлох нь чухал асуудал юм.

Олон нийтийн газар гэдэг нь үндсэндээ нийтийн хэрэгцээнд ашиглах зориулалт бүхий газрыг ойлгоно. (жишээлбэл, нийтийн тээвэр, түүний зогсоол, иргэд чөлөөт цагаа өнгөрөөх хэрэгцээг нь хангах худалдааны төвүүд, ресторан, амралтын спортын гэх мэт газруудыг ойлгоно).

Эдгээр газруудын аюулгүй байдлын байдал нь хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагууд,

цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх хамгийн чухал үзүүлэлт гэж зүй ёсоор тооцогддог.

Гэмт хэргийн үзүүлэлтийг хууль сахиулах байгууллагын дотоод үнэлгээнд голчлон ашигладаг дэлхийн ихэнх улс орнуудад энэ аргыг оновчтой гэж хүлээн зөвшөөрдөг бөгөөд иргэдийн олон нийтийн газрын аюулгүй байдлын талаарх үнэлгээ нь аюулгүй байдлын системийн үр нөлөөг тодорхойлоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсын аймаг нийслэл хотууд сум дүүрэгт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлыг зохицуулах эрх зүйн үндсэн актууд болох Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрт энэ чиглэлээр баримтлах төрийн бодлогын чиг хандлагыг тусгасан.

Үндсэн хэсэг

Олон нийтийн газрын аюулгүй байдлын талаарх иргэд, олон нийтийн санаа бодол хандлагыг үнэлэхдээ хэд хэдэн чухал зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй.

Нэгдүгээрт. Олон нийтийн санаа бодол нь тодорхой үзэгдэл, үйл явцад хүмүүсийн үзүүлэх хандлагыг илэрхийлэх хэлбэрүүдийн нэг юм. Энэ нь эргэн тойрны бодит байдлын талаарх тодорхой ойлголт, аюулгүй байдлын агуулгын талаарх санал бодол, итгэл үнэмшил, иргэд олон нийтийн гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх ойлголт (хохирогч, гэмт хэрэгтэн аль аль нь), бусад нийгмийн гишүүдийн үзэл бодлоос хамаарна. Хууль сахиулах

байгууллагын зорилго, бодит үйл ажиллагаанд хандах хандлага чухал ач холбогдолтой.

Хоёрдугаарт.

Санал асуулгын явцад илэрхийлсэн олон нийтийн санал бодол нь хүмүүсийн бодит хандлага ямар байгаа тухайлбал, цагдаагийн талаар юу гэж боддог, авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар ямар бодолтой байгааг тодорхой болгож байдаг. Иргэд олон нийтийн зүгээс цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахад бэлэн гэж мэдэгдэж болох ч хамтран ажиллах талаар юу ч хийхгүй хайхрамжгүй хандах нь элбэг. Тодорхой зөрчлийн талаар цагдаагийн байгууллагад мэдэгдэлгүй, нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээ авахгүй, олон нийтийн газрын аюулгүй байдал хангалтгүй байна гэж дүгнэх хандлага ажиглагдах.

Гуравдугаарт.

Аюулгүй байдлын түвшин, түүнчлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх хүмүүсийн хандлага нь дараахь үндсэн дээр тулгуурладаг:

Цагдаагийн байгууллагатай харилцаж байгаа иргэдийн, ойр дотны хүмүүсийн (хамаатан садан, хөршүүд, хамт ажилладаг хүмүүсийн) санал бодол;

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүмүүст өгч байгаа мессеж (сонин, телевизийн нэвтрүүлэг, интернет орчинд дахь мэдээллийн урсгал);

Цагдаагийн байгууллагаас иргэдийг хүлээн авч уулзах, олон нийтийн газар хэв журам сахиулах ажлыг гүйцэтгэх үед өгсөн мэдээлэл, түүний дотор албан ёсны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл;

Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчдөөс (Ерөнхийлөгч, УИХ, Хотын дарга, ИТХ-аас) цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ.

Дөрөвдүгээрт. Иргэд олон нийтийн цагдаад хандах бодит хандлагыг нь тэдний итгэл, дэмжлэг, үл итгэх байдал, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг буруушааж буй тодорхой үйлдлүүдээс харж болно.

Нэг талаас иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах, үйлдсэн болон бэлтгэж буй гэмт хэргийн талаар мэдээлэх, гэмт этгээдийг баривчлахад туслах, цагдаагийн байгууллагад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эерэг талыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зэрэгт оролцох боломжтой. Нөгөө талаас иргэд олон нийт цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахыг хүсэхгүй, алба хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд нь эсэргүүцэх, цагдаагийн байгууллагын талаар сөрөг мэдээлэл, янз бүрийн цуурхал тараах, үйл ажиллагааны үр дүнгийн талаар бусдад буруу ташаа ойлголт өгөх талтай.

Монгол Улсын томоохон хот суурин газрын аюулгүй байдлын талаарх иргэдийн хандлага ямар түвшин байгааг тодорхойлох зорилгоор хүн амын янз бүрийн давхарга хэсгийг төлөөлсөн 225 иргэдээс санал асуулгын хэлбэрээр түүвэр судалгаа авч дүгнэсэн.

Асуултуудын дийлэнх хувь нь хаалттай шинж чанартай байсан ба Б.Лайкерт, Э.Богардус нарын аюулгүй байдлын түвшин,

цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хандах хандлагыг үнэлэхэд ашигласан аргыг ашиглан олон нийтийн газрын аюулгүй байдалд хандах иргэдийн хандлагын талаар судалсан.

Эмпирик материалын статистик боловсруулалтыг SPSS програм хангамжийн бүтээгдэхүүнийг ашиглан хийсэн бөгөөд энэ нь олж авсан өгөгдлийн чанарыг үнэлж, тэдгээрийг бүлэглэх боломжийг олгосон. түүнчлэн янз бүрийн үзүүлэлтүүдийн хоорондын хамааралыг тогтоож өгдөг.

Иргэдийн үзэж байгаагаар хамгийн аюул учирч болох эрсдэлтэй газрыг санал асуулгад оролцогчдын 46.0% нь баар ресторан, 22.8% нь нийтийн тээвэр, 22.0% нь гудамж талбай, 21.6% нийтийн тээврийн зогсоолууд, 19.4% нь цахилгаан шат, орц, 17.1% нь амралтын газар, 14.5% такси, 12.3% нь худалдааны газрууд гэж хариулсан бөгөөд дэлгүүр, цэцэрлэгт хүрээлэн, спортын талбайг харьцангуй аюулгүй гэж үздэг.

Нийтийн тээвэр, нийтийн тээврийн зогсоол, такси, цахилгаан шат, орцонд суухаас эрэгтэйчүүдээс 1.5-2 дахин илүү эмэгтэйчүүд болон өндөр настай хүмүүс эмээдэг талаар сонирхолтой үр дүн гарч ирж байна.

Үүний зэрэгцээ судалгаанд оролцогчдын 11.4% нь сүүлийн жилүүдэд олон нийтийн газар байх нь илүү аюулгүй болсон гэж хариулсан бол судалгаанд оролцогчдын 66.4% нь өөрийн амьдарч байгаа газраа бусад газруудаас илүү аюултай гэж үзсэн байна.

Зураг 1. “Олон нийтийн газар ямар аюул заналхийллээс хамгийн их болгоомжлох ёстой вэ?”

№	Хариулт	%
1	Эд зүйлсээ хулгайд алдах	53,2%
2	Дээрэмдүүлэх (эрүүл мэндээ хохирол учруулах, эд зүйлээ алдах)	44,0%
3	Танхай (бусдад доромжлогдохоос)	27,7%
4	Эрүүл мэндээ ноцтой хохирол учруулах	35,2%
5	Халдлагад өртөх	25,5%
6	Тээврийн хэрэгслээ хулгайд алдах (мотоцикль, скутер, унадаг дугуй)	8,8%
7	Бэлгийн дарамт	8,8%
8	Залилан	8,4%
9	Бусад аюул заналхийлэл	3,5%

Иргэдийн үзэж байгаагаар нэгдүгээрт хулгай, дээрэм, халдлага хоёрдугаарт, танхайрах зөрчлийг хамгийн их аюул учруулж байна дүгнэж байгаа нь тодорхой харагдаж байна. Энэхүү судалгаа нь олон нийтийн газарт үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх албан ёсны статистик мэдээлэлтэй хамааралтай болохыг харгалзан цагдаагийн байгууллагаас судалгаагаар гарч ирсэн халдлагаас урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Олон нийтийн газар явахдаа иргэдийн 50-иас доошгүй хувь нь айдаг айдсыг бууруулж чадвал цагдаагийн байгууллага, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг иргэд илүү ихээр итгэх итгэлийг нэмэгдүүлэх боломжийг олгоно.

Үүний зэрэгцээ олон нийтийн газар гэмт хэргийн хохирогч болсон эсэх талаарх санал асуулгын дүн

анхаарал татаж байна - Судалгаанд хамрагдсан иргэдийн 77.0% нь хүн бүр амьдралынхаа туршид дор хаяж нэг удаа олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч болдог гэж үзсэн.

Судалгаанд хамрагдсан дөрвөн хүн тутмын нэг нь (26.0%) сүүлийн зургаан сарын хугацаанд гэмт хэргийн хохирогч болсон гэж хариулсан. Сүүлийн нэг туршид судалгаанд оролцсон иргэдийн 56.3% нь ойр дотны хүмүүс нь олон нийтийн газарт халдлагын хохирогч болсон хариулсан.

Хохирох эрсдлийн түвшин маш өндөр байгаа нь олон нийтийн газар аюулгүй байдлыг хангах хүчин чармайлтын үр дүнтэй байдлын талаарх сөрөг хандлагыг иргэдийн дунд түгээж байна. Үүнээс гадна хүмүүс дахин гэмт хэргийн хохирогч болох магадлал нэлээд өндөр байна гэж судалгаанд оролцогчид үзэж байна (Зураг 2).

Зураг 2. “Олон нийтийн газар гэмт хэргийн хохирогч болох магадлал хэр байна вэ?”

№п/п	Хариулт	%
1	Надад ийм зүйл тохиолдохгүй	44,3%
2	Надад ийм зүйл тохиолдох нь юу л бол	28,2%
3	Хэнч ийм тохиолдлоос хамгаалагдаагүй	1,3%
4	Үүнээс зайлсхийх боломжгүй	16,3%
5	Хариулахад хэцүү байна	10,1%
НИЙТ		100%

Олон нийтийн газар гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн 44% энэ хэргийн талаар цагдаад гомдол гаргаагүй нь онцлог. Мөн цагдаагийн байгууллагад хандсан иргэдийн дөнгөж 30,8 хувь нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн дөнгөж 6.6% нь олон нийтийн газар гэмт хэргийн хохирогч болсон талаараа цагдаад мэдэгддэг гэж үзсэн бол 43.1% нь хохирогчдын дийлэнх нь цагдаад ханддагүй гэж үзсэн.

Цагдаагийн байгууллагад хандахаас татгалзах шалтгаан нь янз бүр байна.

- Тэд өөрсдийн эрх ашгийг хуулиар хамгаалдаг гэдгийг мэддэггүй (50.2%);
- Гэмт этгээдүүдийг олж, хариуцлага тооцно гэдэгт итгэдэггүй (31.2%);
- Мөрдөн байцаалтад оролцохыг хүсэхгүй байна (23.8%);
- Цагдаагийн байгууллага туслана гэдэгт итгэхгүй байна (20.7%);
- Хууль дагуу шийдвэрлэхгүй гэж үздэг (17.6%);
- Гэмт этгээдүүдээс айж байна (17.6%);

- Илүү асуудал хүсэхгүй байна (13.2%);

- Хохирсон талаар хүмүүст мэдэгдэхийг хүсэхгүй байна (12.8%);
- Надад тийм ч их хохирол учруулаагүй гэж үзэж байна (5.7%).

Иймд иргэд цагдаад хандахаас татгалзах гол шалтгааныг иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг гэж дүгнэж болох ч энэ асуудал нь нөгөө талаар цагдаагийн алба хаагчдын ажлын үр дүн чанартай холбоотой.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд олж авсан тоо баримт нь Монгол Улсад олон нийтийн газарт иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн зүгээс авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг илүү өргөн хүрээтэй бодит үйл ажиллагааг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгааг нотлон харуулж байна.

Нэн тэргүүнд хохирсон иргэдийн эрх зүйн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, өөрийн өмчийг хамгаалах, хувийн аюулгүй байдлыг хангах талаар иргэдэд зориулсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх,

мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэх чанарыг сайжруулах, олон нийтийн газар аюулгүй байдлыг хангах хамгийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх, хохирогчдын цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх мэргэжлийн цагдаагийн дүр төрхийг бий болгох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Ашигласан материал

1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14700>
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр
3. **Комплексное предупреждение преступлений, совершаемых в общественных местах в городах Монголии** <https://omamvd.ru/diss/?p=2412>